

# Тоглоом IOI 96

Хоёр тоглогч самбар дээр тавьсан  $N$  ( $2 \leq N \leq 200$ ) ширхэг эерэг бүхэл тоогоор тоглоно. 1-р тоглогч тоглоомыг эхэлнэ. Тоглогчид ээлжлэн самбар дээрх тоон дарааллын баруун эсвэл зүүн захаас сонгоно. Сонгосон тоо нь самбараас хасагдах бөгөөд тухайн тоглогчийн оноонд нэмэгдэнэ. Самбар дээрх тоонууд ээлжлэн сонгогдсоор дуусахад хамгийн их оноотой тоглогч нь хожно.

Уг тоглоомыг тоглох хамгийн шилдэг тактикийг олох програм бич. Хамгийн шилдэг тактик нь байж болох хамгийн сайн өрсөлдөгчийн эсрэг тоглоход түүнээс илүү оноо цуглуулж чадах тактик юм. Програм нь 2 дахь тоглогчийн хувьд мөн шилдэг тактикийг олох ёстой.

**ПРОГРАМЫН НЭР: game1**

## ОРОЛТЫН ФОРМАТ

1-р мөр:	$N$ , самбарын хэмжээ
2-р мөрөөс төгсгөл:	Самбар дээрх тоонууд зүүнээс баруун тийш дарааллаар байна. 1-ээс 200 хооронд $N$ бүхэл тоо.

## ЖИШЭЭ ОРОЛТ (файл game1.in)

6

4 7 2 9

5 2

## ГАРАЛТЫН ФОРМАТ

Зайгаар тусгаарлагдсан 2 бүхэл тоо байна. Эдгээр нь тоглогч тус бүрийн оноо. 1-р тоглогчийн оноо эхэндээ байна.

## SAMPLE OUTPUT (file game1.out)

18 11

Орчуулсан Б.Даваабаяр